

**“МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО,
ҮНДСЭН БОЛОН ГҮЙЛГЭЭНИЙ САНГИЙН ЗАРЛАГЫН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Улсын Их Хурлаас Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын болон байнгын бус хэсэгт байвал зохих эрдэнэсийн нэр төрөл, хэмжээг тогтоох, үндсэн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах, гүйлгээний сангаас жил бүр зарцуулах хэмжээг тогтоохоор заасныг үндэслэн Монголбанкнаас ирүүлсэн санал, түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн сан болон гүйлгээний сангийн зарлагын 2022 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, уг тогтоолын төслийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хаалттай хуралдаанаараа хэлэлцлээ.


Хэлэлцүүлгийн явцад гишүүдээс тодорхой санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжиж, нэгдсэн хуралдаанд оруулан анхны хэлэлцүүлгээр батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан ... бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.” гэж заасны дагуу “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн сан болон гүйлгээний сангийн зарлагын 2022 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



C. Цэрэнпунцаг

С.ЧИНЗОРИГ